

unicef 

НҮБ-ын Хүүхдийн Сан

**МАЛЧИН ГЭР БҮЛ,
ОРОН НУТГИЙН ОЛОН
НИЙТИЙГ СУРГУУЛЬД
БЭЛТГЭХ НЬ:
НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН АРГА
ЗАМ ХАНДЛАГА**





**МАЛЧИН ГЭР БҮЛ,
ОРОН НУТГИЙН ОЛОН
НИЙТИЙГ СУРГУУЛЬД
БЭЛТГЭХ НЬ:
НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН АРГА
ЗАМ ХАНДЛАГА**

© НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)
2020 он
Монгол улсад хэвлэв.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)
НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж - 14
Улаанбаатар 14201
Монгол Улс

Утас: (976-11) 312185, 312217
Факс: (976-11) 327313
www.unicef.mn



Хураангуй

2015-2030 оны Тогтвортой хөгжлийн зорилгууд нь насан туршийн боловсролыг чанартай боловсрол олгох тогтолцооны салшгүй хэсэг болохыг хүлээн зөвшөөрсөн юм. 1990-ээд онд сургуульд сураагүй, эсвэл завсардсан, бичиг үсэггүй хүүхдүүд, залуучууд болон боловсрол муутай насанд хүрэгчдэд хүрч, тэднийг боловсролд хамруулах зорилгоор Монголд албан бус боловсролыг (АББ) нэвтрүүлсэн юм. Одоо үүнийг Насан туршийн боловсролын (НТБ) тогтолцоо гэж мэдэх болсон хэдий ч, боловсролын салбарын үндсэн бүрэлдэхүүн гэж үзэхээсээ, нөхөн сэргээх, засах явцуу хүрээнд ойлгодаг нь хэвээр байна. Тус улсад насан туршийн боловсролын чадамжтай, тухайлбал, алслагдмал нутаг орон оршин суугаа малчин өрхийн бага насны хүүхдэд хүрч ажиллах чадвартай тогтолцооны шаардлага хэрэгцээ байсаар байна. Үнэн хэрэгтээ, асран халамжлагч гэр бүл, сургуульд бэлтгэх орон нутгийн олон нийтийн сургалтын төв зэрэг насан туршийн боловсролын шинэлэг хандлагууд, бага насны хүүхдийн хөгжлийн талаар, Монголд тогтсон, хот сууринд төвлөрсөн тогтолцоонд дулдуйдсан өрөөсгөл хандлагыг даван туулахад нэмэр болох билээ.

1. Өмнөтгөл: Насан туршийн боловсрол нь боловсролын бодлогын үндсэн концепц болох нь

2015-2030 оны Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилгод чанартай боловсролыг анхаарлын төвд тавьж, бүгдийг хамарсан, “нийтлэг, чанартай боловсрол олгох, бүх хүмүүсийн насан турш сурах боломжийг дэмжих” зорилго тавьсан юм.

Түүхэнд анх удаа насан туршийн боловсрол суралцахуйг боловсролын салшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг ийнхүү хүлээн зөвшөөрсөн юм. Энэ бол, албан бус боловсрол, техник, мэргэжлийн боловсрол, сургалтын төв (ТМБСТ), насанд хүрэгчдийн бичиг үсгийн сургалт гэж ойлгогддог насан туршийн боловсролыг албан боловсролын хавсарга гэдэг ойлголтыг орхиж, насан туршийн боловсролын хувь нэмрийг дэмжин дэлгэрүүлэхэд эргэлтийн үе болж байна. Иймээс, ТХЗ-ын 4 дэх зорилго нь үндэсний боловсролын салбарын хүртээмж, хамралтыг улам өргөтгөн, сайжруулахын хамт, үндэсний боловсролын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн хувьд, ажлын байрт чиглэсэн чадвар, мэдээлэл, харилцааны технологийг илүү анхаарахыг боловсролын салбарын хариуцах үүрэг болгож байгаа юм.

Насан туршийн боловсрол бол бүхэлдээ шинэ концепц, шинэ хөтөлбөр биш юм. Бүх нийтийн боловсролын хөдөлгөөн (БНБ), Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ), Инчоно 2030 хүртэлхи Боловсролын төлөө үйл ажиллагааны хүрээний Тунхаглал зэрэг дэлхийн боловсролын өмнөх хөтөлбөрүүдэд, үе дамжсан ядуурал, нийгмийн гадуурхал, байгаль орчны асуудлууд болон ажил эрхлэлтийн талаар дэлхийн хэмжээнд гарч байгаа өөрчлөлтийг (Инглиш ба Карлсен, 2019, НҮБ ТХЗ 2019) уламжлалт бус боловсролын хэлбэр, түүний үүрэг, ач холбогдлыг цаашид хүлээн зөвшөөрөх суурийг тавьсан байдаг.

Хайрцаг 1: Тогтвортой Хөгжлийн дөрөв дэх зорилго: Голлон анхаарах асуудлууд

Тогтвортой хөгжлийн дөрөв дэх зорилго бүх нийтийн чанартай боловсролын ерөнхий зорилгыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох дараахь хэдэн асуудлуудыг заан тодорхойлсон байдаг, үүнд:

- 4.1 Үнэ төлбөргүй, тэгш бөгөөд чанартай боловсрол
- 4.2 Бага насны хүүхдийн халамж, сургуулийн өмнөх боловсрол
- 4.3 Техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол
- 4.4 Залуучууд, насанд хүрэгчдийн зохистой ур чадвар
- 4.5 Боловсролын тэгш хүртээмж
- 4.6 Насанд хүрэгчдийн бичиг үсэг болон тооны чадвар
- 4.7 тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжих
- 4.а Боловсролын барилга байгууламжууд
- 4.б Хөгжиж буй орнуудад тэтгэлэг олгох
- 4.в Мэргэжилтэй багш нар

Насан туршийн боловсролыг дэмжих бүтээлч хандлага нь энэ концепцийг хоорондоо харилцан уялаатай гурван хэмжигдэхүүн болгож, тухайлбал, (1) бичиг үсгийн боловсрол нь насан турш суралцах үйл явц, (2) бичиг үсэг бол амьдралын өргөн хүрээнийн үйл явц; ба (3) бичиг үсэг бол насан туршийн боловсролын тогтолцоог дэмжих салбарын түвшний шинэчлэлийн нэг хэсэг гэж задалж болох юм. Энэ аргыг ашиглан, тогтвортой хөгжлийн дөрөв дэх (ТХЗ) зорилгыг хэрэгжүүлэх талаар гарсан ахиц дэвшлийг дүгнэн үзэхэд, бичиг үсгийн тайлагдалт, боловсролыг өргөн хүрээнд тавих алсын хараа шаардлагатай хэмжээнд хүрээгүй байна (Ханеман, 2019). Цаашилбал, насан туршийн боловсрол, Тогтвортой

Хөгжлийн дөрөв дэх зорилгын чухал дөрвөн тулгуур асуудлыг анхаарлын төвд авчирч байна, үүнд:

- **Бүх насны хандлага, арга зам:** Амьдралын турш суралцахуйн үйл явц явагдаж байдаг;
- **Тэгш байдал:** бүх нийтийн суурь чадварын хэрэгцээ шаардлага байна;
- **Хамралт:** Бүх нийтийн зохистой ажлын төлөө сурах;
- **Чанар:** нийгэм болон иргэний амьдралд бүрэн дүүрэн оролцохын төлөө сурах

Гэвч, насан туршийн боловсролын асуудал, Монголд ч, бусад улс оронд ч, бодлого боловсруулагчдад сорилт бий болгож байдаг, учир нь энэ нь чухам ямар үр дагавартай болох талаар ойлголтын зөрөөнөөс шалтгаалдаг байна. Нэгдмэл санаа оноо, зөвшилцөлд хүрээгүй нөхцөлд үүнийг хэрэгжүүлж, дэлхийн, бүсийн болон улс орны түвшинд ахиц дэвшлийг үнэлэхэд бэрхшээлтэй болно. Түүгээр зогсохгүй, ойлголтын хүрээг тодорхойлж чадаагүй бол тогтвортой хөгжлийн бусад зорилгуудыг биелүүлэхэд чухал нөлөө үзүүлэх насан туршийн боловсролыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болох юм. Эдгээр зорилгууд нь: эн тэргүүнд, тогтвортой хөгжлийн тав дахь зорилго-ТХЗ- 5 (Жендерийн тэгш эрх), ТХЗ- 3 (Эрүүл мэнд ба аж байдал) болон ТХЗ- 8 (Зохистой ажил болон эдийн засгийн өсөлт); тэрчлэн, ТХЗ-12 (Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл) мөн ТХЗ- 13 (Уур амьсгалын өөрчлөлтийг хазаарлах) (АНДЭЗНК, 2019, Инглиш ба Карлсен, 2019) зэрэг юм. Иймээс, насан туршийн боловсрол буюу суралцахуй нь боловсролын чадавхи болон зорилгыг өргөн хүрээнд хамарч, урт хугацааны тогтвортой хөгжлийн боломжийг бий болгох ба тэгснээрээ, ТХЗ-ын тэргүүлэх зорилгуудын нэг болж байгаа юм. Үнэн хэрэгтээ, “боловсролын бодлогын үндсэн концепц, боловсролыг зохион байгуулах зарчим болох”-ынх хувьд, насан туршийн боловсролыг хүлээн зөвшөөрөх орчин бий болгохын төлөө, боловсролын гол гол асуудлуудын эргэн харах ёстой юм (Инглиш ба Карлсен, 2019).

Өнөөдөр ч гэсэн, боловсролын чанар, тэгш байдал болон боловсролын хамрагдалт, сурган хүмүүжүүлэх сургалт, боловсролын үр дүн, сурагчдыг сургуульд нь тогтоох болон албан бус боловсрол, түүний дотор техникийн, мэргэжлийн боловсрол зэргийг харуулсан үзүүлэлтүүдэд дутуу, харин, бага

боловсролын хүртээмж, төгсөлт зэрэг асуудалд илүү ач холбогдол өгсөөр байгаа билээ. 2017 онд, дэлхийн хэмжээгээр, 6-17 насны 262 сая хүүхдүүд сургуулийн гадна байсан бөгөөд тэдний тэн хагасаас илүү нь унших болон тооны наад захын суурь чадваргүй байв. Дэлхий даяар, боловсролын салбар нь технологийн хурдацтай өөрчлөлттэй хөл нийлүүлж чадалгүй хоцорсон ба, хүний амьдралын бүх салбарт, ялангуяа, эмэгтэйчүүд, охид, гадуурхагдсан, ихэнхидээ хүний нүдэнд өртдөггүй шахам үндэсний цөөнхийн бүлэгт хамаарагдах хүүхэд, өсвөр насныхны боловсролын үр дүнг сайжруулахын төлөө илүү хүчин чармайлт тавих шаардлагатай байна. (НҮБ ТХЗ 2019). Эцсийн дүндээ, үндэсний засгийн газрууд, боловсролыг, бичиг үсэг, тоо бодох чадвараас гадна илүү өргөн хүрээнд харж, насан туршийн боловсрол\суралцахуй гэж ойлгож хүлээж авсан хойно л, энэ нь ТХЗ-ийн хэрэгжилтэд өөрчлөлт шинэчлэлтийн нөлөө үзүүлж чадна.

2. Монголын насан туршийн боловсролын хөтөлбөр: саад учруулахуйц нөхцөл байдал

Монгол улсад, Насан туршийн боловсролын үндэсний төв нь (НТБҮТ) Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны харъяанд ажиллаж, насан туршийн боловсролын асуудлыг хариуцдаг. Сая болтол, үүнийг албан бус боловсрол (АББ) хэмээн явцуу хүрээнд ойлгож ирсэн юм. Тиймээс, тэндээс зохион байгуулж байсан хөтөлбөр, сургалтууд нь гурван чиглэлийг л хамарч байсан, үүнд, насанд хүрэгсдийн бичиг үсгийн хөтөлбөр, дүйцүүлэх хөтөлбөр болон нэмэлт туслах хөтөлбөр, сургалтууд (жишээ нь Англи хэлний унших, бичих сургалт). НТБҮТ нь бодлого боловсруулах, хяналт үнэлгээний судалгаа, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, материал боловсруулах, үндэсний түвшинд хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг ажил үүргийг гүйцэтгэдэг (Ембүү, 2009).

1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжих үед албан бус боловсролд анх удаа тэргүүлэх ач холбогдол өгч байсан билээ. Тэр үед АББ-ын гэгээрлийн төвүүд зорилтот 2 бүлэгтэй байсан, үндсэн зорилтот бүлэг нь сургуулийн гадна байгаа болон сургуулиас завсардсан хүүхдүүд, залуучууд, тэрчлэн, бичиг үсэггүй, боловсрол багатай насанд хүрэгчид юм. Онцгой зорилтот бүлэг нь ажилгүй, гэрийн ажилтай эмэгтэйчүүд, боловсролоо дээшлүүлэх зорилготой

шилжин ирэгсэд, нялх хүүхэдтэй эцэг, эхчүүд зэрэг насанд хүрэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчдээс (гэх мэт...) бүрддэг. Үнэн хэрэгтээ, бодлогын гол үр дүн нь сургууль завсардсан хүүхдүүд, өсвөр насныханд зориулсан Дүйцүүлсэн хөтөлбөр юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхан болон мөн шилжиж ирсэн гэр бүл, нийгэм- эдийн засгийн эмзэг байдалд байгаа хүмүүст боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх, тэднийг илүү хамрах зэрэгт үнэлэхүйц ахиц дэвшил гаргахад нөлөөлсөн байна.

Эдгээр төвүүд Япон зэрэг орнуудад байдагтай адилгүй, өөрийн байр гэж байхгүй, сум, эсвэл аймгийн захиргаанаас бие даасан санхүүжилт авдаггүй. Харин, төвүүд албан сургуулиудын байранд байрлан, жишээ нь АББ-ын багшийг томилох, төвийн үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр сургуулийн удирдлагатай хамтран ажилладаг. Ийнхүү, дунджаар 2000-15,000-аас бага хүн амтай сум болон аймгийн санхүүгийн болон хүний нөөцийг дээд зэргээр үр дүнтэй ашигладаг.

Ерөнхийдөө, АББ-ыг нэвтрүүлэх талаар ахиц дэвшил удаан байсан бол, одоо яг байр нь солигдоод, насан туршийн боловсролын (НТБ) хөгжил ч мөн тийм түвшинд байна. АББ-ын гэгээрлийн төвүүдийг НТБ-ын төв гэж өөрчлөн нэрлэсэн. Гэвч, мөн л адил бэрхшээлтэй тулгарч байгаа ба, НТБ-ыг боловсрол олгодог биш нөхөн сэргээх үүрэгтэй гэж үзсэн хэвээр байна. Тиймээс, тэдгээр төвүүдийг хөрөнгө оруулалтын хомсдолтой, чадавхи дорой, дэд бүтэц муу гэж тодорхойлдог. Энэ байдал нь, ихэнхидээ ганц, эсвэл хоёр өрөөнөөс бүрдсэн НТБ-ийн төвд хуваарилдаг туйлын бага нөөцөөс харж болно. Төвд, НТБ-ын бага ангийн багшийн мэргэжилтэй ганц багш сумын бүх хүн амын хэрэгцээг хангаж, аймгийн сургууль бүрт НТБ-ын нэг багш ажиллаж, аймгийн боловсролын газарт нэг арга зүйч ажиллаж байна. Сумын түвшинд, 1-9 дүгээр ангийн хүүхдүүд төлөвшил, боловсролын түвшин болон сурах чадвараас үл хамааран нэг дор хамт сурдаг.

Хөрөнгө оруулалтын хомсдол, төвүүдийг ердийн сургуулийн байранд нэгтгэж байгаа чухамхүү энэ байдлын шалтгааныг засгийн газрын өндөр дээд шатанд НТБ-ыг өрөөсгөлөөр ойлгож, нийгмийн өргөн хүрээнд дутуу ойлголттой, буруу ташаа хүлээн авдагтай холбож болно. Цаашилбал, бодлогын хувьд тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байгаа нь, НТБ-ын холбоотой асуудлыг БСШУСЯ-ны холбогдох бусад газар, тухайлбал, Дээд боловсролын газар, тэрчлэн, Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яаманд (ХНХЯ) харъяалагддаг Техникийн мэргэжлийн боловсрол, сургалтын газар авч үзэхгүй, орхигдуулж байгаагаар илэрч байна.

Эцэст нь, Монголын алслагдсан нутагт амьдарч буй, малчин өрх, хагас нүүдлийн болон шилжин ирсэн хөдөө суурингийн оршин суугчдын талаар тоо баримт, мэдээлэл ховор байдаг нь тоо баримт мэдээллийн бэрхшээлийг учруулж байна. Тоо баримт дутуу байдаг хүндрэл бүсийн хэмжээний асуудал юм. ТХЗ-ын үзүүлэлтүүдийн гуравны нэгийг, түүний дотор 17 дахь ТХЗ-ыг хэмжих боломжгүйг Ази, Номхон далайн бүсийн ТХЗ-ын ахиц дэвшлийн талаар хамгийн сүүлийн үед гаргасан тайланд (АНДЭЗНК, 2019) дүгнэн гаргажээ. 2020 гэхэд өндөр чанар бүхий тоо баримтыг цаг хугацаанд нь боловсруулан гаргах байдлыг үлэмж нэмэгдүүлнэ гэсэн ТХЗ-ын 17 дахь зорилгыг систем дэс дараатай хэрэгжүүлэх үүргээ бүс биелүүлж чадахгүй байгаа нь хамгийн гол бэрхшээл болж байна. Ийм эрчээр үргэлжилбэл, ямар ч ТХЗ-ыг, түүний дотор ТХ-ийн дөрөвдэх зорилгыг биелүүлж чадахгүй гэдгийг Тайлан илгтэлд онцлон дурьджээ.

2.1. Хэнийг ч ард орхихгүй: Малчин өрхийн хүүхдүүд

Нүүдлийн соёл иргэншилтэй, хүн ам сийрэг нөхцөлд, насан туршийн боловсролыг өргөн хүрээнд харж, хандах нь бүх нийтийн амьдралын бүх шатанд тэгш, бүгдийг хамарсан чанартай боловсрол олгох зорилтыг хэрэгжүүлэх үйл явцыг түргэсгэх үр нөлөөтэй. Гэвч, боловсролын талаар, бодлого хэлэлцэх явцад болон олон нийтийн үзэл бодолд ноёрхож буй хуучинсаг ойлголтоос улбаалан, уялдаа холбоотой стратеги төлөвлөгөө байхгүй байна.

Тухайлбал, боловсрол олгох үйл явц нь түүхийн хувьд малчин өрхийг хот суурин руу шилжин нүүх, улмаар суурин амьдралын хэв маягийг дагахад хүргэсэн. Чухамдаа боловсролыг явцуу хүрээнд авч үзвэл, энэ нь зонхилох тохиолдолд нийгмийн байгууламж, өрхийн эдийн засгийг өргөн хүрээнд, нэгмөсөн солиход хүргэдэг соёлын өөрчлөлтийн үйл явц юм. Монгол орны хувьд, боловсрол нь бусад хүчин зүйлийн хамт, аажмаар “малчны” хэв маягийг хаях явцад нөлөөлсөн ба ингэснээр, малчин өрхийн нэлээд олонхи нь сайн дураараа хот суурин руу шилжиж, суурин амьдралтай болсон ба, эсвэл, хүүхдээ төв суурин газар сургуульд сургахын тулд эцэг эхийн нэг нь хүүхдээ дагаж өрх бүл тусдаа амьдрах болсон юм.

Хүн амын 60-аас дээш хувь хот сууринд төвлөрсөн орчин үед алслагдсан нутгийн малчны хүүхдүүд цөөнхи нь болжээ. Гэвч, орон зайны хүчин зүйлээс шалтгаалж, сургуулийн өмнөх боловсролын боломжийг тэд ихэвчлэн ашиглаж чадахгүй үлддэг ба энэ нь хамгийн гол бэрхшээл болж байдаг. Зарим гэр бүл хамгийн ойрын төв суурингаас 100-200 километр алслагдсан зайд амьдардаг тул, малчин өрх дунджаар 60-70 километр газрыг туулж байж, төв хүрдэг (Ембүү 2009).

Иймээс, суурь боловсролын хүртээмжийн асуудал, хүүхэдтэй малчин гэр бүлийн өмнө өвөрмөц шаардлагыг тавих, эсвэл, хүүхдээ албан сургуульд хамруулахаас өөр аргагүй нөхцөлд хүргэдэг. Сургуульд бэлтгэх шатнаас эхлээд, их дээд сургуульд сурах хүртэл шилжилтийн бүх үе шатанд, малчин өрхийн хүүхдүүд системийн гадна үлдэх, эсвэд завсардах эрсдэлтэй тулгарч байдаг (НҮБХС 2014). Эцэстээ, уламжлалт мал маллах ажлаа үргэлжлүүлэх үүднээс гол төлөв хөвгүүд орхигдон үлдэх магадлал өндөр.

3. Сургуулийн бэлтгэл: гэр бүл, орон нутгийн оршин суугчдад суурилсан насан туршийн боловсрол/ суралцахуйн хандлага, арга зам

Насан туршийн боловсролын бүрэлдэхүүн хэсэг-сургуульд бэлтгэх ажил нь Монгол орны малчин өрх, гэр бүлийн хувьд туйлын үр нөлөөтэй арга зам бөгөөд, ТХЗ-ийн дөрөвдэх зорилгыг хэрэгжүүлэхэд чухал суурь болсон, амьдрал туршийн хандлага, тэгш байдал, хамралт, боловсролын үр дүнгийн чанар зэрэг дөрвөн тулгуурыг бүрдүүлэхэд гэр бүл, орон нутгийнханд эерэг дэм болно.

Сургуульд бэлтгэх энэхүү онолын хүрээ нь анхаарлыг боловсролын байгууллагаас холдуулж, хүүхдийн төрөлх орчин болон гэр бүл, оршин сууж буй орон нутгийн орчин руу чиглүүлэхэд нөлөөлнө. Сургуульд бэлтгэх арга зүйн хүрээнд тулгуурлах нь бага насны хүүхдийн сурахтай холбоотой бодлого боловсруулах, стандарт хэм хэмжээг тодорхойлох, орхигдож хаягдсан хэсэгт эн тэргүүнд анхаарахын тулд сурах боломжийг албан сургуулиас гадна илүү өргөн хүрээнд бүрдүүлэх

зэрэг олон талын үйл ажиллагаа явуулахыг шаардана. Эцэг эхийн болон гэр бүлийн дэмжигч орчин бага сургуульд сурах үед болон түүнээс цаашид тэгш байдлыг тогтоох, амжилттай суралцахыг урьдчилан тодорхойлох хамгийн чухал нөхцлүүдийн нэг юм. Түүгээр зогсохгүй, эдгээр нөхцөл нь насанд хүрэх хүртэл нь нийгмийн болон зан үйлийн эерэг чадварыг тогтоон шингээснээр насан туршийн үр дүн гардаг (НҮБХС, 2012).

Тархай бутархай хүн амд, Хойд болон Төв Европын орнуудын хэрэгжүүлдэг сургуульд бэлтгэх арга зам үр дүнтэй байж мэдэх юм: энэ туршлагаар бол, сургуульд бэлтгэх үйл ажил хүүхэд, гэр бүл, оршин суугаа орон нутгийн олон нийт гэсэн гурван үндсэн тулгууртай. Тиймээс, гэр бүлийн бэлэн байдал бол бас нэгэн үндсэн ойлголт юм. Жишээ нь хүүхэд төрөхөөс эхлээд яваандаа хүүхдээ сургуульд явуулах хүртэл, гэр бүлийг бэлтгэх асуудал ордог (НҮБХС, 2012). Хүүхдээ сургуульд явуулах тухай гэр бүлийн шийдвэрээс, хүүхэд сургуульд дасан зохицох нь төвөг багатай болохыг судалгаа харуулдаг тул, гэр бүлд төвлөрөн ажиллах нь нэн чухал ач холбогдолтой. Өрх гэр салангид байж сургуульд бэлтгэх нь гүн гүнзгий үр дагавартай төдийгүй, нэлээд олон тохиолдолд Монгол дахь гэр бүлийн бүтцийг мөнхөд өөрчлөн задлах нөлөө үзүүлдэг. Түүний оронд сургуульд сурах бэлтгэлийг чухалчлан үздэг боловсролын тогтолцоо бол хүүхдийн гэр бүл, оршин суугаа орон нутаг дахь олон нийтийн орчныг оролцуулахыг идэвхитэй хайн эрэлхийлдэг.

Үнэн хэрэгтээ насан туршийн суралцахуйн арга хандлага бол тэгш байдал, хамралт, чанарын зарчмыг хэрэгжүүлдэг төдийгүй, дэлхий даяархи суурьшмал бус амьдралын хэв маягийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг ба улмаар, хөгжин дэвжих бололцоогоор хангахыг эрмэлздэг. Малчин хүн амд сургуулийн бэлтгэлийн чухал ач холбогдолтойг Монголд аажмаар ойлгож, тэр ойлголт улам илүү бэхжиж байна. 2015 оноос өмнө, алслагдсан хүн амд хүрч ажиллахын тулд сумын АББ-ын багш нар хэд хэдэн санаачилга гаргасан боловч тэдгээр нь малчин өрхийн хувьд олигтой амжилтад хүрээгүй бөгөөд, цаашдаа улирлаар төлөвлөх шаардагатай болсон (Ембүү, 2009). 2015 онд, харилцан шүтэлцээтэй зайн сургалтын багц ашиглан эцэг эх хүүхдээ сургах аргыг дэмжиж, Улаанбаатарын хоёр дүүрэг, Хөвсгөл аймагт, өрхөд буюу гэр бүлийн орчинд тулгуурласан бага насны

хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг НҮБХС хэрэгжүүлж эхэлсэн. Мөн саяхнаас, хөдөөгийн хүүхдэд зориулсан өрх-гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрийг Хүүхдийг ивээх сан туршин хэрэгжүүлж эхэлснийг хүмүүс сайшаан хүлээн авлаа. Гэвч хэдийгээр БСШУСЯ-ны хүлээсэн үүрэг эрмэлзлэл байгаа хэдий ч, бага сургуульд орохоос өмнөх эхний зургаан сард өрхийн сургалтаар, орон нутгийн олон нийтэд тулгуурлан явуулах сургуульд бэлтгэх хөтөлбөрийг өргөжүүлэн хэрэгжүүлэхэд санхүүгийн хомсдол тулгарч байна.

3.1. Зөвлөмжүүд

- Гэр бүл, оршин суугаа нутгийн олон нийтийн орчин: Сургуульд бэлтгэх хөтөлбөрийг хүргэх анхдагч талбар нь гэр бүл, оршин суугаа нутгийн олон нийт юм. Сургуульд бэлтгэх асуудлаархи ихэнхи судалгаа гэр бүлийн энгийн бөгөөд идеалист загварыг сонгосон байдаг. Сургуульд бэлтгэх явц болон гэр бүлийн динамикийн харилцан үйлчлэл, хувь хүний хувьд, гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн дасан зохицол, харилцаа холбоо тогтоох, ойр дотнын харилцаа зэрэг нийгэм-сэтгэл хөдлөлийн зан үйлийн үеэс үед дамжин уламжлах байдал, танин мэдэхүйн чадвар, хүүхэд бусад ах дүү нарын хоорондын харилцаа гэх мэт тэдний сурах үйл явцад нөлөөлөн, хэлбэржүүлдэг асуудлаар улам олон янзын судалгаа явуулах шаардлага байсаар байна (Кован ба бусад, 2005, НҮБХС иш татсан 2012).
- Сургууль ба албан бус боловсрол: ТХЗ-ын 4 дэх зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө тууштай ахиц дэвшил гаргахын тулд, насан туршийн боловсролыг өргөн хүрээнд боловч нягтаршилтай хэрэгжүүлэх стратегийг Монгол улс эн тэргүүнд боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нэгдүгээрт, насан туршийн боловсролын төвүүдийн санхүүгийн болон хүний нөөцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дараа нь чадваржуулах болон нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна. Хоёрт, техникийн, мэргэжлийн боловсрол сургалтыг насан туршийн боловсролыг өргөжүүлсэн, нягтралтай стратегид мөн нэгтгэн оруулах шаардагатай. Эдгээр нь хамгийн эмзэг бүлэгт хамаарагдах хүүхдүүд, өсвөр насныхныг олж тодорхойлон, тэдэнд хүрч ажиллахад хамгийн чухал ач холбогдолтой асуудлууд юм.

- Эрүүл мэндийн халамж, нийгмийн үйлчилгээ: Эрүүл мэндийн халамж, нийгмийн үйлчилгээ нь малчин эцэг эх, гэр бүл, нутгийн олон нийтийг “сургуульд бэлтгэх” ажилд дэмжих сургах явдал чухал үүрэгтэй. Төрөхийн өмнөөс эхлээд, төрсний дараахь халамж, нярай болон нялх хүүхдийг багаас нь идэвхижүүлэн дэмжих болон бага насны хүүхдийн халамж үйлчилгээнээс эхэлдэг, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх практик ажиллагаа нь хүүхдийн сурах, хөгжихийг дэмжих ёстой (ДЭМБ 1999). Үнэн хэрэгтээ жирэмсэн байх үе болон төрсний дараахь 100 хоног хүүхдийн тархины хөгжил идэвхитэй явагддаг онцгой чухал бөгөөд энэ үе нь насан туршийн үр нөлөөтэй эмзэг үе юм. Энэ нь жирэмсэн үед болон хүүхдийн бага насанд сайн хоол тэжээл, цэвэр агаар, аюулгүй амны усны чухлыг онцлон чухалчилдаг.
- Нийгмийн хамгаалал, хууль зүйн тогтолцоо: Нийгмийн болон хөдөлмөрийн холбогдолтой бодлогууд шинээр эцэг эх бологсдод, улмаар сургуульд бэлтгэх асуудлыг багтаасан бага насны хүүхдийн халамжид шууд нөлөөлж тусгалаа олдог. Албан сургуульд элссэхийг урамшуулдаг нийгмийн хамгаалал нь алслагдсан, хагас нүүдлийн хэв маягтай гэр бүлүүдэд үр ашгаа өгдөг ба, насан туршийн боловсролд тэгш бөгөөд хамралтад чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Цахим болон цахим бус харилцаа холбоо: Залуучууд, ялангуяа хот суурин газрын монголчууд, өөрийн нутаг орондоо биеийн болон орон зайн хувьд тусгаарлагдсан хэвээр байгаа ба, харин, дэлхийн мэдээлэлд нэвтрэх, улс орны өнцөг бүрт байгаа үе тэнгийнхэнтэйгээ холбогдоход интернет хүчирхэг талбар болдог. Тиймээс, хүрч очиход бэрхшээлтэй, малчин гэр бүл зэрэг хүн амтай холбогдох шинэ боломжийг цахим технологи олгож байгаа юм. Асар удам энэ газар нутагт биеэр хүрэхэд төвөгтэй нөхцөл байдлыг харгалзан, цахим орон зайг илүү сайн судалж ашиглах нь алс холын хүн амд хүрч ажиллах маш чухал хөрс болж байгаа юм.

Бодлогын энэхүү товч мэдээлэл нь НҮБХС-аас, Хөгжлийн Замтай хамтран 2019 онд гаргасан “Өсвөр үеийнхний цогц хөгжлийн нөхцөл байдлын үнэлгээ, 2019” –д үндэслэсэн болно.

Лавлагааны бусад материалууд

- АНДЭЗНК (2019) Ази, Номхон далайн ТХЗ-ын ахиц дэвшил, тайлан:<https://www.unescap.org/sites/default/files/Part_I_Asia-Pacific_SDG_Progress_Report2019.pdf> холбоосоор үзэж болно.
- АХБ (2017) Монгол улса: Эдийн засгийн хүнд үед чанартай боловсрол олон хүртээмжийг тогтоон барих төлөс, Төсөл удирдах гарын авлага
- НҮБХС (2012) Сургуульд бэлтгэх тухай Концепцийн хүрээ. <[https://www.unicef.org/earlychildhood/files/Child2Child_ConceptualFramework_FINAL\(1\).pdf](https://www.unicef.org/earlychildhood/files/Child2Child_ConceptualFramework_FINAL(1).pdf)> холбоост бий.
- Инглиш ба Карлсен(2019) Насан туршийн суралцахуй\боловсрол ба Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ): Үр нөлөө ба үр дүнг судлахуй, Боловсролын олон улсын ревью
- Ембүү, Б. (2009) Албан бус боловсролын салбарын дүн шинжилгээ, Монгол улс, ЮНЕСКО, Монголын боловсролын их сургууль болон Албан бус болон зайн сургалтын үндэсний төв.
- ДЭМБ (1999) Чухал холбоо: Биеийн болон сэтгэл зүйн хөгжилд оролцох нь, Женев хот
- <http://data.unescap.org/sdg/#datahome>



НҮБ-ын Хүүхдийн Сан

© НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)

2020 он

Монгол улсад хэвлэв.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)

НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж - 14

Улаанбаатар 14201

Монгол Улс

Утас: (976-11) 312185, 312217

Факс: (976-11) 327313

www.unicef.mn